



Н.Павлюк
ОХУ-ын Улс түмний найрамдлын их сургууль
(УТНИС)-ийн профессор



С.Эрдэнэмаам
МУБИС-ийн НХУС-ийн Орос хэл, арга зүйн
тэнхимийн багш, профессор

ХЭЛ ЗААХ АРГАД ОРЧУУЛГЫГ АШИГЛАХ НЬ

Аннотация: Стало уже классическим представление о том, что человек воспринимает реальность через национальную лингвокультурологическую призму. Поэтому мировосприятие представителей различных этносов может существенно различаться. Очевидно, что наибольшие национально-культурные различия проявляются не в научных или деловых текстах, а в художественной литературе, особенно в поэзии. Эту специфику прекрасно знают переводчики, которые считают, что в художественном переводе должны отражаться не столько денотаты, сколько особенности национального восприятия реалий.

Түлхүүр үг: үндэстэн-соёлын ялгаа, оросын соёл, яруу найраг, төрөлх хэлний болон ахуй соёлын онцлог.

Аливаа хүн бодит байдлыг үндэснийхээ хэл-соёлын шүүлтүүрээр хүлээн авдаг гэсэн үзэл бодол эдүгээ сонгодог ойлголт болжээ [1]. Тийм ч учраас янз бүрийн угсаатны төлөөлөл ертөнцийг өөр өөрөөр хүлээн авдаг аж. Харин үндэстэн-соёлын ялгаа эрдэм шинжилгээний болон албан бичиг баримтад бус, уран зохиолд, ялангуяа яруу найрагт илүү их тодордог байна. Энэхүү онцлогийг орчуулагч нар нарийн сайн мэддэг бөгөөд уран сайхны орчуулгад тухайн үгийн денотат¹ /заагдагч/-ыг орчуулна гэхээсээ илүүтэйгээр тухайн үндэстэн бодит ертөнцийг хэрхэн тусган авч буй онцлогийг харуулах хэрэгтэй гэж тэд үздэг ажээ.

Жишээлбэл, английн нэгэн оготор шүлэг

(Лимерик²)-ийг орос хэлэнд орчуулахдаа С.Маршак “Бар”-ыг “Баавгай”-гаар сольсны зэрэгцээ эхэд ганцхан залуу охины тухай өгүүлдэг байхад “зоригт гурван бүсгүй” хэмээн орчуулж, харин газар усны нэр (Niger)-ийг орхисон байдаг. Гэтэл уг орчуулгыг тухайн шүлгийн орчуулга дотроос хамгийн сайнд тооцдог байна. Англи хэлний багш нар англи богино шүлэг заахдаа энэ шүлгийг хичээл дээр их хэрэглэдэг байна:

Эх	Орос орчуулга
There was a young lady of Niger, Who smiled as she rode on a tiger: They returned from the ride With the lady inside – And the smile on the face of the tiger.	Улыбаясь, три смелые леди Разъезжали верхомна медведе. Вернулись всетри У медведя внутри, А улыбка – на морде медведя.

Аливаа үндэстэн ястан ертөнцийн юмс үзэгдлийг мэдэрч хүлээн авах үйл явцад хэл зүйн ай, тухайлбал хүйсийн ай чухал үүрэгтэй байна. Өөрөөр хэлбэл:

1. тухайн угсаатны хэлэнд хүйсийн ай бий эсэх, байх аваас хэрхэн илэрдэг болох тухай асуудал;
2. тухайн хэлэнд тухайн үг аль хүйсэд хамаардаг, эс хамаардаг тухай асуудал. Жишээлбэл, “бургас” хэмээх утгатай “Ива” гэдэг үг орос хэлэнд эм хүйст, литов хэлэнд (Glosnis) эр хүйст хамаардаг байна.

3. аль нэгэн хүйсийн үгийг зүйрлэлийн үүргээр

² Лимерик — Их Британид анх үүссэн, 5 мөр богино шог шүлэг (С.Э.).

¹ Денотат - denotatum хэмээх латин үгээс гаралтай, заагдагч эд юм гэсэн утга (С.Э.).

ашиглах боломж байгаа эсэх асуудал. Жишээлбэл, оросын яруу найрагт өргөн дэлгэр хэрэглэдэг “берёза” гэдэг үгийг орчуулахдаа Литва улсын орчуулагчид ихээхэн бэрхшээлтэй тулгардаг байна, учир нь тухайн орос үгэнд тохирох литов хэлний “biarzas” хэмээх үг эр хүйсийнх аж. «Зеленая прическа, девическая грудь, о, тонкая березка, что засмотрелась в пруд» (үгч. Ногоон үстэй, нүцгэн цээжтэй, цөөрмийг ширтэн мэлрэх туяхан бургасхан минь дээ) гэсэн мөрүүдийг литов хэлэнд орчуулахдаа “бургас”-т тохирох үг нь эр хүйсийнх учраас “Puisale” (“сосенка” - нарсхан) хэмээх эм хүйсийн үгээр орлуулдаг байна [3. С. 22].

Орос хэлийг гадаад хүнд заахад оросын соёл, яруу найрагтай заавал танилцуулдаг учраас энэ бүхийг харгалзан үзэх учиртай бөгөөд эдүгээ ч харгалзан заасаар байгаа билээ. Тухайлбал, УТНИС-ийн инженерийн факультетын орос хэлний тэнхимээс оросын яруу найргийн өдрүүдийг жил бүр зохион байгуулж, энэ үеэр гадаадын оюутнууд орос яруу найрагчдын шүлгийг уншиж, тэдгээрийн уран бүтээлтэй улам ойртон танилцдаг.

Оюутнуудын шүлэг уншиж байгаа байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд орос хэл судалж буй гадаад оюутнууд төдийгүй, шүлэг уншиж буй оюутнууд хүртэл орос яруу найргийн нарийн ширийнийг төдийлөн сайн ухахгүй байгаа нь харагдав.

Москвэд аж төрж суугаад орос хэл үзэж буй оюутнууд ийм байхад гадаад орнуудад, бүр улс орныхоо бөглүү сум сууринд суугаад орос хэл судалж буй оюутан, сурагчдын хувьд байдал нэн хүнд байдаг нь ойлгомжтой билээ. Тухайлбал, Монгол улсын Боловсрол, шинжлэх ухааны яамны албан ёсны мэдээгээр бол тус улсын 300 мянга гаруй оюутан, сурагч орос хэл үзэж, түүгээр дамжуулан оросын агуу их яруу найрагтай танилцаж байна. “Гэхдээ Монгол улсын нийслэлд англи болон бусад зарим гадаад хэлийг орос хэлнээс хоёр дахин илүү их анхааран судалдаг бөгөөд харин хөдөө орон нутагт бол орос хэл судлахыг зайлшгүй чухалд тооцсоор байгаа” юм [2. С. 46].

Аль ч улс орны сургуульд, тухайлбал, Монгол улсад оросын яруу найрагтай танилцуулах сургалт дараах бүдүүвч маягаар явагдаж байна:

Орос шүлэг → монгол орчуулга → агуулгын тайлбар

Ийнхүү тайлбарлаж заахад шүлгийн хамаг давс хужир, тухайлбал, хүйсийн айн онцлог “амтагдахгүй” өнгөрч байгаа юм. (монгол хэлэнд тухай ай байхгүй учир).

Иймд бид орос, монгол хэл соёлын хооронд гүүр болох үүднээс арга зүйн дараах нэгэн алхмыг боловсруулан туршсан юм:

Монгол яруу найрагчдын шүлэг → орос орчуулга → тайлбар

Ийм дарааллаар сургалтыг зохион байгуулахад өөрийнх нь төрөлх хэлний болон ахуй соёлын онцлог өөр хэлний “толинд” хэрхэн буудаг тухай төсөөллийг сурагчдад сайн ойлгуулж болох талтай мэт. Үүнтэй холбогдуулаад яруу найрагч Чагнаагийн Пүрэвдоржийн “Гэргий” шүлэгт С.Эрдэнэмаам хадмал орчуулга хийж, Н.Павлюкийн орчуулсныг жишээ болгон авч үзье:

Эх	Хадмал орчуулга	Орчуулга
Чийдэн хэрэгтэй, Чийдэн хэрэгтэй гэгцгээдэг. Чийдэн ч хэрэгтэй л дээ. Чингэвч, Гэргий минь, би Чинийхээ гэрэлд Зохиолоо бичдэг	Нужна лампа, нужна лампа,- Говорят и твердят люди. Лампа, конечно, нужна и важна, Однакоже, жена моя, Я пишу при свете от тебя	Волшебная лампа тебе нужна: Поэт Должен видеть свет. Волшебная лампа тебе нужна, Без нее света нет! Волшебная лампа мне не нужна: Чудо, дарящее свет, - Это моя жена! Без нее света нет...

Шүлгийн эхэд байхгүй волшебный (шидэт), чудо (гайхамшиг), дарящий (бэлэглэгч) гэх зэрэг шинэ үг хэллэг орчуулгад орж ирж байгаа учраас чудо– чудесный – чудеса; волшебный – волшебник - волшебство; дарящий – дарить – дар гэх зэргээр утгын үүр үүсгэх замаар тэдгээрийн агуулгыг тайлбарлана. Орос шүлэг, яруу найрагт өргөн дэлгэр хэрэглэдэг эдгээр үгийн агуулгыг хүйсийн ай ашиглан тайлбарлаж ойлгуулах нь цаашдаа сурагчид орос яруу найрагтай улам гүнзгий танилцахад нэмэртэй юм.



Яруу найрагч Ч.Пүрэвдоржийн бүтээлээс орос хэлний сургалтад хэрэглэж байгаа бас нэг шүлгийг авч үзье:

Эх	Хадмал орчуулга	Орчуулга
Эрдэмтэн болов оо, би Эрдэмтэдтэй нийлэв ээ, хөөрхий. Эрэл хайгуул Элдэв судалгаа Эцэс төгсгөлгүй. Судлаад л байв, Судлаад л байв. Судалж судалж... Малч эцгийн хэлсэн үг Мадаггүй болохыг мэдэв ээ.	Стал я учёным, ё моё, В ряд с учёными встал. Поиски, поиски... Конца им нет. Что же делать? Исследование, исследование... Днями и ночами изучение И наконец-то установил: Истина последней инстанции Это слова отца моего – скотовода.	Понятно ведь, Что не для скуки Я грыз всю жизнь гранит науки, Ходил, ходил в читальный зал И слово истины искал. Хотя профессором уж стал, Все слово мудрости искал... И вот: То слово Еще с детства знал Отец мой – скотовод...

Энэ шүлгийн агуулгыг танилцуулахдаа скука – скучный - скучать; истина -истинный; ведь – ведать; мудрость - мудрый гэх зэрэг үгийн, мөн грызть гранит науки хэмээх хэвшмэл хэллэгийн утгыг тайлбарлан ойлгуулах шаардлагатай болно. Суралцагчдын мэдлэгийн түвшин, судалж буй сэдэв нэг бүрээс хамаарч ямар найрагчийн аль шүлгийг сонгохоо тухай багш шийдэх учиртай байна. Тухайлбал, ахисан түвшинд Пушкин, Лермонтовын уран бүтээлтэй танилцуулахын өмнө монголын нэрт зохиолч Лодонгийн Түдэвийн “Уулс” шүлгийг Я.Белинскийн орчуулснаар уншуулах нь нэлээд үр дүнтэй байна:

Эх	Орчуулга
Хөрст их дэлхийн бууралхан тэргүүн Хөх мөнх тэнгэрийн буурьтай багана Хөвөн их үүлсийн залрах өндөрлөг Хөлгүй уст мөрний ундрах газар Уулс чиний сарьдаг оргил бардам Уудам хорвоод толгой бөхийсөн удаагүй Уулс чиний сүрлэг өлмий бат Уужим дэлхийд тахим нугалсан цаггүй Тэнүүлчин үүлс чамайг мөргөн няцарна. Чи бүхний дээрээс өнгийн ширтэнэ. Чи бүхний дундаас өндийн сүндэрлэнэ. Чиний дээрээс бүгд өчүүхэн үзэгдэнэ. Чиний дороос бүгд өлийн ширтэнэ. Уулс чиний сарьдаг оргил бардам Уудам хорвоод толгой бөхийсөн удаагүй Уулс чиний сүрлэг өлмий бат Уужим дэлхийд тахим нугалсан цаггүй Гэвч чиний тэргүүнд хүний мөр гарчээ. Гэвч чиний өлмийг хүний зөрөг гаталжээ.	Седая голова планеты древней нашей, Колонна, на которую оперся небосвод, В тебе - источник рек, ты - каменная чаша, Ты - великан, что облака пасет. Горда твоя вершина, непреклонна, Над нею только синева и тишь, Твои столпы - крутых отрогов склоны. Ты ни пред кем колен не преклонишь. С гранитной кручи, с высоты надменной Ты смотришь вниз, угрюмый исполин, На жалкий мир, ничтожный, мелкий, бранный, Таким порой он кажется с вершин... Твои столпы - крутых отрогов склоны, Ты ни пред кем колен не преклонишь. Но на уступах, в небо устремленных, - Упрямый жгут протоптанной тропы, И на челе, на глыбах раскаленных - След человечьей маленькой стопы.

Л.Түдэвийн энэхүү шүлгийн орчуулгад XIX-р зууны оросын яруу найрагт өргөн дэлгэр тохиолддог источник, непреклонно, отроги, бранный мир, преклонить колени, чело, стопа гэх зэрэг тансаг найруулгын үг хэллэг нэлээд орсон байдаг учраас түүнийг ийнхүү ашиглах нь оросын сонгодог яруу найргийг судлахад танин мэдэхүйн ихээхэн ач холбогдолтойгоос гадна хичээлийн явцыг мэдэгдэхүйц хөнгөвчилж байгаа нь ажиглагдсан билээ.

Толилуулж буй арга барилыг УТНИУ, МУБИС-д туршиж үзсэн нь үр нөлөөтэй болохоо харуулсан бөгөөд бусад улс оронд ч орос хэлний сургалтад хэрэглэж болно хэмээн үзэж байгаа юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Маслова В. А. (2001). Лингво культурология: Учебн. Пособие для студ. высш. учебн. заведений. — М.: Издательский центр «Академия»
- Наумов, А. (2008). Русский след в Монголии. *Русский мир*, 9, 38-46.
- Павлюк Н.А. (2009). Категория рода и гендерная лакуна. Вестник Российского университета дружбы народов. *Серия ВОПРОСЫ ОБРАЗОВАНИЯ: языки и специальность*, 3, 21-25.